



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 5/153

Улаанбаатар хот

М.Цэрэн-Очирт сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, Архивын ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журмын 6.1.14, 6.2.3, 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн Цахим сангийн төвийн цахимжуулалт хариуцсан ажилтан М.Цэрэн-Очирт сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг, сар бүрийн төлөвлөгөөт ажлын норм болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай биелүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг М.Цэрэн-Очирт үүрэг болгосугай.

3. Дээрх зөрчлийг гаргахгүй байхыг цахимжуулалт хариуцсан нийт ажилтанд анхааруулж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /Л.Уянга/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 1 сарын дотор дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХБААТАР



Tushaal
368110723